



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2026.06.10 № 01/3666

танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар дараах мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. Дунд, ахлах ангийн суралцагчдыг өдрийн хоолны үйлчилгээнд хамруулах боломжийн талаар.

2025-2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 717 сургуульд 739 982 суралцагч суралцаж байгаа бөгөөд 1-5 ангид 341083 суралцагч үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа нь нийт суралцагчдын 47.2%-ийг эзэлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулиар суралцагчдын үдийн хоолны үйлчилгээнд тэгш хамруулахаар заасан хэдий ч дунд болон ахлах ангийн сурагчид уг хөтөлбөрт хамрагдаж эхлээгүй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 4000-5000 төгрөг, ирцийг 100 хувь байхаар тооцоход жилд 305,2 тэрбум төгрөг шаардлагатай юм.

Үдийн хоол хөтөлбөрт хамрагдах суралцагчийн “Үдийн хоол”-оор авбал зохих шим тэжээлийн нормативаас тооцсон түүхий эдийн зардлын төсөөлөл

Анги	Суралцагчийн тоо /2026-2027 прогноз/	Хичээллэх хоногийн тоо	Хоолны түүхий эдийн зардал /төг/	Шаардагдах санхүүжилт /сая,төг/
VI	68,158	175	4000	42,939.5
VII	70,587	175	4000	44,470.0
VIII	69,363	180	4500	50,564.9
IX	64,900	180	4500	47,312.4

1426111366

X	51,665	180	5000	41,848.9
XI	46,225	185	5000	38,482.9
XII	47,503	185	5000	39,546.5
БҮГД				305,165.3

Суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулахад зөвхөн түүхий эдийн зардал төдийгүй хүүхдийн тооны өсөлттэй уялдсан хүний нөөц, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог оновчтой болгох зэрэг шийдвэрлэх олон асуудлууд хөндөгдсөөр байна.

Тухайлбал төрийн өмчийн 509 сургуульд нэмэлт тоног төхөөрөмж, 70 сургуулийн дотоод орчинд хоол үйлдвэрлэлийн газрыг өргөжүүлэх, 159 сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт их засвар /агааржуулалт, цахилгаан, цэвэр, бохир усны өргөтгөл, өрөө тасалгааны зохион байгуулалт, төлөвлөлтийг өөрчлөх/ хийх шаардлагатай бөгөөд үүнд нийтдээ 130 гаруй тэрбум төгрөг шаардлагатай болно.

Бидний зүгээс сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын орчин, нөхцөлийг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах, оролцогч талуудад хоол шим тэжээлийн боловсрол олгох, судалгаа, үнэлгээний чиглэлээр олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн.

Койка олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд 2025 онд нийслэлийн ерөнхий 48,40,9 дүгээр сургуульд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг өргөтгөх, их засвар хийх, цахилгааны хангамжийн өргөтгөл хийж, чанар стандартын шаардлага хангасан орчинд үдийн хоолны үйлчилгээг үзүүлж байна. Цаашид энэ онд багтаан 7 сургуулийн хоол үйлдвэрлэлийн газрыг засварлаж, иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах ажил хийгдэж байна.

Мөн төслийн хүрээнд “Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт аргагүйн төв”-ийг ШУТИС-ийг түшиглэн байгуулж нээлтээ хийлээ. Энэ төв нь боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүний нөөцийн тасралтгүй хөгжлийг хангах, боловсролын үйлчилгээнд оролцогч талууд болох удирдлага, багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, хүнс ханган нийлүүлэгчдэд хоол, шим тэжээлийн боловсрол мэдлэг олгох, энд суралцаж буй оюутан, ажиллаж буй багш эрдэмтэд дэвшилтэд технологид суурилсан сургалт, судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн сургуулийн хоолны хөтөлбөрийг шинжлэх ухаанчаар хөгжүүлэх зорилго бүхий Монгол улсад байгуулагдаж байгаа анхны төв болж байгаагаараа онцлог юм.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6.1-т “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартын шаардлага хангасан зориулалтын байр, гал тогоо, тоног төхөөрөмж ашиглан мэргэжлийн

хүний нөөцтэйгөөр явуулна” гэж, мөн 6.5-т “Сургуульд хоол зүйч, мэргэжлийн тогооч, туслах тогооч ажиллах бөгөөд суралцагчийн тооноос хамаарч бэлтгэгч, угаагч, үйлчлэгч ажиллана” гэж тус тус заасан.

Энэ хичээлийн жилд 302 хоолзүйч, 978 тогооч, 924 туслах тогооч эрүүл, аюулгүй үдийн хоолны үйлчилгээг дээрх суралцагчдад үзүүлж, улсын төсвөөс тэдгээрийн цалинд 5,6 тэрбум төгрөгийг төсөвлөн зарцуулж байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тогтоолын төсөлд дунд, ахлах ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулахад 279 хоолзүйч, 1593 тогооч, 1138 туслах тогооч шаардлагатай тооцоо судалгаа гарч байна.

2. Үдийн хоолны үйлчилгээнд бага ангийн суралцагчдыг хамруулснаар бий болсон эерэг, сөрөг үр дагавар, үр нөлөөний талаар

Боловсролын яам, Дэлхийн банктэй хамтран бага боловсролын түвшинд сурлагын чанарт ямар хүчин зүйлүүд эерэг болон сөргөөр нөлөөлж буйг илрүүлэх зорилгоор 2005 онд бага боловсролын сурлагын амжилтын үнэлгээг хийсэн. Тус үнэлгээнд хичээл дээрээ өлсдөг хүүхдийн сурлагын амжилт өлсдөггүй болон заримдаа өлсдөг хүүхдийнхээс доогуур үнэлэгдсэн. Тухайлбал: Математикийн хичээл 7.3-13.6 хувиар, Монгол хэлний хичээл 12.7-18 хувиар доогуур байдлаар сурлагын амжилт нь үнэлэгдсэн байна.

Иймээс Монгол Улсын Засгийн газраас бага боловсролд хамрагдаж буй хүүхдийн суралцах үйлийг дэмжих зорилгоор 2006 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс бага ангийн сурагчдад үдийн цайны үйлчилгээг хүргэж эхэлсэн бөгөөд сургууль завсардалт буурч, хүүхдийн хичээлд анхаарал төвлөрөлт, суралцах хүсэл нэмэгдсэн гэж аудитын дүгнэлтэд дурдсан байдаг.

Мөн 2021-2025 онд Жайка олон улсын байгууллагын төслийн хүрээнд Дундговь, Өвөрхангай аймаг болон нийслэлийн сонгогдсон сургуулийн хүүхдүүдэд шим тэжээлийн тэнцвэртэй цэсээр үйлчлэх, сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэн өмнөх болон дараах гэсэн харьцуулсан судалгааг хийсэн байдаг. Судалгаагаар өдөр бүр сүү өгснөөр сурагчдын өндөр 3см орчмоор нэмэгдэж, ясны эдийн нягтын үзүүлэлт эрс сайжирсан дүн гарсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.4.1-т эрүүл мэндийн асуудалд эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сургуулийн хүүхдийн хоол тэжээлийн байдлын судалгааг таван жил тутамд гаргаж, үр дүнг холбогдох төрийн байгууллага болон олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээсэн. Түүнчлэн судалгааны дүнд үндэслэн хүүхдийн зохистой хооллолт болон эрүүл хүнсний талаар зөвлөмж гаргах, мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулах, Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжлийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хэмжээг үндэслэн сургуулийн хүүхдийн хоол хүнснээс авбал зохих илчлэг шим тэжээлийн хэмжээг тодорхойлохоор заасан байдаг. Иймд хуульд заасан уг судалгааг хийж, үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгааг үүгээр дурдах нь зүйтэй.

3. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 5.1.1 дэх заалтын хэрэгжилтийн талаар

Яамны зүгээс Улсын Их Хурлын тамгын газар, Өргөдлийн байнгын хороотой хамтран ажиллаж, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 2030 он хүртэл авч хэрэгжүүлэх арга хэмжээ түүнд зарцуулагдах төсөв, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт бүхий “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.

Тогтоолд ерөнхий боловсролын сургуулийн 6-7 дугаар ангийн суралцагчдыг 2027-2028 оны хичээлийн жилээс, 8-9 дүгээр ангийн суралцагчдыг 2028-2029 оны хичээлийн жилээс, ахлах ангийн суралцагчдыг 2029-2030 оны хичээлийн жилээс эхлэн үдийн хоолны үйлчилгээнд хамруулахаар зааж, шаардлагатай төсөв, хүнсний хангамж, хоол үйлдвэрлэлийн орчин, хүний нөөцийг бүрдүүлэх, судалгаа үнэлгээг хийх зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох яам, төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой тусгасан.

Иймд дээрх тогтоолыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, 2027 оны төсөв хэлэлцэх үед онцгой анхаарч, хамтарч ажиллахыг хүсье.



Л.ЭНХ-АМГАЛАН